

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/086/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> <a href="#">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: <a href="mailto:bayasgalanj@audit.gov.mn">bayasgalanj@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.СӨРӨГ ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Албан шаардлага.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>38,995,700.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>9,666,000.00</b>
<b>33300</b>	Татаас санхүүжилтийн авлага		9,666,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		<b>23,770,000.00</b>
34600	Урьдчилж төлсөн зардал		23,770,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>5,559,700.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>5,559,700.00</b>
35410	Бичиг хэргийн материал		1,287,200.00
35420	Аж ахуйн материал		3,432,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл		0.0
35440	Түлш, шатах тослох материал		840,000.00
35450	Барилгын засварын материал		0.0
35470	Бусад хангамжийн материал		0.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>71,514,553.24</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>71,514,553.24</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>70,345,803.27</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц		0.0
39202	Хуримтлагдсан элэгдэл		0.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл		0.0
39204	Хуримтлагдсан элэгдэл		0.0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		45,549,430.19
39206	Хуримтлагдсан элэгдэл		(5,775,014.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		32,854,475.56
39208	Хуримтлагдсан элэгдэл		(2,283,088.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө		0.0
39215	Хуримтлагдсан элэгдэл		0.0
39217	Ном		0.0
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>1,168,749.97</b>
39301	Программ хангамж		1,375,000.00
39302	Хасагдуулга		(206,250.03)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>110,510,253.24</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>9,666,000.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>9,666,000.00</b>
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		9,666,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>100,844,253.24</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>100,844,253.24</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>100,844,253.24</b>
51220	Тайлант үеийн үр дүн		100,844,253.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>110,510,253.24</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>371,257,450.81</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>39,879,293.14</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>39,879,293.14</b>

	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,000,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,879,293.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>331,378,157.67</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,740,000.00</b>
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	<b>10,740,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>320,638,157.67</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,638,157.67
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>270,413,197.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>270,413,197.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>240,518,538.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>178,235,123.42</b>
210101	Үндсэн цалин	94,259,232.85
210102	Нэмэгдэл	58,117,513.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,091,353.15
210104	Урамшуулал	11,347,600.00
210105	Гэрээтийн цалин	8,419,424.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,350,646.03</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,294,665.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,754,507.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	861,893.91
210204	Ажилгүйдлийн даатгал	857,681.91
210205	Эрүүл мэндийн даатгал	3,581,896.85
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,823,413.22</b>
210401	Бичиг хэрэг	4,107,150.00
210402	Тээвэр, шатахуун	6,360,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,263.22
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,042,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,042,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,267,816.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,267,816.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	45,000.00
210807	Газрын төлбөр	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,799,539.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,799,539.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,894,659.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,894,659.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,954,659.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		10,940,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>100,844,253.24</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>100,844,253.24</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>333,378,157.67</b>
	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>2,000,000.00</b>
	Нийтлэг татварын бус орлого		2,000,000.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого		2,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх		2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		331,378,157.67
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>10,740,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,740,000.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		320,638,157.67
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага		320,638,157.67
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>292,943,357.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>292,943,357.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>263,048,698.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>178,235,123.42</b>
210101	Үндсэн цалин		102,678,656.85
210102	Нэмэгдэл		58,117,513.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,091,353.15
210104	Үр дүнгийн урамшуулал		11,347,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>22,350,646.03</b>
210201	Тэтгэврийн даатгал		15,294,665.51
210202	Тэтгэмжийн даатгал		1,754,507.85
210203	ҮОМШӨ-ний даатгал		861,893.91
210204	Ажилгүйдлийн даатгал		857,681.91
210205	Эрүүл мэндийн даатгал		3,581,896.85
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>16,350,613.22</b>
210401	Бичиг хэрэг		5,394,350.00
210402	Тээвэр, шатахуун		7,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,356,263.22
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>17,922,500.00</b>
210604	Урсгал засвар		17,922,500.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>		<b>16,042,000.00</b>
210702	Дотоод албан томилот		16,042,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>12,147,816.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		12,102,816.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		0.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		45,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>29,894,659.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>20,228,659.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		18,954,659.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,274,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		<b>9,666,000.00</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		9,666,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>40,434,800.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>40,434,800.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		40,434,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		40,434,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		40,434,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>(40,434,800.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	100,844,253.24	100,844,253.24
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	100,844,253.24	100,844,253.24

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>394,369,000.00</b>	<b>322,638,157.67</b>	<b>71,730,842.33</b>	<b>81.8</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,369,000.00	322,638,157.67	71,730,842.33	81.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,369,000.00	322,638,157.67	71,730,842.33	81.8

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>233,283,900.00</b>	<b>178,235,123.42</b>	<b>55,048,776.58</b>	<b>76.4</b>
210101	Үндсэн цалин	128,518,500.00	102,678,656.85	25,839,843.15	79.9
210102	Нэмэгдэл	78,886,900.00	58,117,513.42	20,769,386.58	73.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,296,000.00	6,091,353.15	4,204,646.85	59.2
210104	Урамшуулал	15,582,500.00	11,347,600.00	4,234,900.00	72.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,410,500.00</b>	<b>22,350,646.03</b>	<b>11,059,853.97</b>	<b>66.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,719,100.00	15,294,665.51	7,424,434.49	67.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,672,900.00	1,754,507.85	918,392.15	65.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,336,400.00	861,893.91	474,506.09	64.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,336,400.00	857,681.91	478,718.09	64.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,345,700.00	3,581,896.85	1,763,803.15	67.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,550,900.00</b>	<b>16,350,613.22</b>	<b>200,286.78</b>	<b>98.8</b>
210401	Бичиг хэрэг	5,508,400.00	5,394,350.00	114,050.00	97.9
210402	Тээвэр, шатахуун	7,039,500.00	7,000,000.00	39,500.00	99.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,373,000.00	1,356,263.22	16,736.78	98.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,630,000.00	2,600,000.00	30,000.00	98.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>57,089,800.00</b>	<b>56,982,300.00</b>	<b>107,500.00</b>	<b>99.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,979,800.00	20,200.00	99.9
210602	Тавилга	19,080,000.00	19,080,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	18,009,800.00	17,922,500.00	87,300.00	99.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,802,000.00</b>	<b>16,042,000.00</b>	<b>1,760,000.00</b>	<b>90.1</b>
210702	Дотоод албан томилолт	17,802,000.00	16,042,000.00	1,760,000.00	90.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,931,900.00</b>	<b>13,522,816.00</b>	<b>409,084.00</b>	<b>97.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,370,000.00	12,102,816.00	267,184.00	97.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	0	44,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,517,900.00	1,420,000.00	97,900.00	93.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,300,000.00</b>	<b>19,154,659.00</b>	<b>3,145,341.00</b>	<b>85.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,300,000.00</b>	<b>19,154,659.00</b>	<b>3,145,341.00</b>	<b>85.9</b>
<b>213208</b>	<b>Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг</b>	<b>21,900,000.00</b>	<b>18,954,659.00</b>	<b>2,945,341.00</b>	<b>86.6</b>

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	200,000.00	200,000.00	50.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,740.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,740.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,740.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>0.0</b>
210101	Үндсэн цалин	0.0
210102	Нэмэгдэл	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0
210104	Урамшуулал	0.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>0.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>10,740.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,074.0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,666.0
<b>1</b>	<b>Зардлын санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>10,740.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,740.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	<b>10,740.0</b>

## 3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Худалдан авах ажиллагааны газар *Цаашид ХААГ гэх* нь “Төрийн худалдан авах ажиллагааг зохицуулсан төрөөс баримтлах бодлого чиглэл, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль тогтоомж, тогтоол шийдвэр, журам зааврыг мөрдлөг болгон хэрэгжүүлэхдээ ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсөвт байгууллагуудын худалдан авах ажиллагаанд хяналт тавих, тайлагнах.

- Худалдан авах ажиллагааны талаар төсөвт байгууллагуудад мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэн чадавхжуулж хуулийн хэрэгжилтийг хангуулах.
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 сарын 05-нд нэмэлт орсон,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 сарын 05-нд өөрчлөлт орсон,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болгосон өөрчлөлт 2024 оны 08 сарын 30-нд орсон,*
- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

ХААГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХААГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн ХААГ нь аймгийн Засаг даргын 2020 оны 07 сарын 16-ны өдрийн А/202 дугаар захирамжаар харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХААГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн **110,510.2** мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0.0	0.0
Авлага		33,436.0	33,436.0
Бараа материал		5,559.7	5,559.7
Үндсэн хөрөнгө		71,514.5	71,514.5
<b>Нийт хөрөнгө</b>		<b>110,510.2</b>	<b>110,510.2</b>
Өр төлбөр		9,666.0	9,666.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		100,844.2	100,844.2
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>		<b>110,510.2</b>	<b>110,510.2</b>

Дээрх хүснэгтээс харахад:

- Тайлант оны эцэст **33,436.0** мянган төгрөгийн авлага үүссэн нь татаас санхүүжилтийн 9,666.0 мянган төгрөгийн авлага, 23,770.0 мянган төгрөгийн урьдчилж төлсөн зардал бүртгэсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл **5,559.7** мянган төгрөг байгаа нь 800,0 мянган төгрөгийн хангамжийн материал, 200,0 мянган төгрөгийн шатахууны талон бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж авсан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 15,026.8 мянган төгрөгөөр бараа материал худалдан авсан болон

10,467.1 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж зарлагадсантай холбоотой байна.

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл **71,514.5** мянган төгрөг байгаа нь тайлант жилийн эхэнд бүтцийн өөрчлөлтөөр 39,344.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил шилжүүлж авсан, төсвийн хөрөнгөөр 40,434.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, программ хангамж худалдан авсан болон 8,264.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсонтой холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс **394,369.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг саналын дагуу дараах байдлаар хянаж, баталсан байна. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 237,525.9 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 29,690.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 18,030.8 мянган төгрөгөөр,
- Томилолт зочны зардлыг 23,052.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 24,249.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 39,519.5 мянган төгрөгөөр,
- Гэрээт ажилтны цалин урамшуулал 29,757.9 мянган төгрөгөөр тооцож нийт **394.369.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 394,369.0 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 322,638.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 322,638.1 мянган төгрөг буюу 81.8 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	338,591.3	294,155.4	44,435.9	86.8
2	Гэрээт ажиллагсдын зардал	33,477.7	9,328.1	24,149.6	27.8
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	22,300.0	19,154.6	3,145.4	85.9
	<b>Дүн</b>	<b>394,369.0</b>	<b>322,638.1</b>	<b>71,730.9</b>	<b>81.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130052401 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 10,740.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ХААГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ХААГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 512 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

ХААГ нь тайлант 2024 онд шинээр байгуулагдсан тул төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв болох 394,369.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,943.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, зөрчилгүй ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ХААГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс дараах 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт 1,2 сар
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал 1,2 сар
- Дараа жилийн төсвийн төсөл 9 сар
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1,2 сар

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.6, 6.4.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

ХААГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 11 сарын 24-ний өдрийн А/586 дугаар захирамжаар Орон нутгийн өмчийн газраас тусгаарлаж үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул өмнөх жилүүдэд бие даасан тайлан гаргаагүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### **5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **23,770.0** мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Бодитоор хүлээж аваагүй урсгал засварын материал болон гүйцэтгээгүй ажлын хөлс болох 17,890.0 мянган төгрөгийг тайланд шууд зардлаар бүртгэснийг урьдчилж төлсөн зардлаар бүртгүүлсэн,
- Ажилчдаа Нура төвд эрүүл мэндийн үзлэгт оруулахаар 5,880.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч, үйлчилгээ аваагүй байхад шууд зардлаар бүртгэн тайланд тусгасан байсныг урьдчилж төлсөн зардлаар тусгуулсан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **41,865.6** мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх 5 албан шаардлага хүргүүлэв.

#### **5.1 Албан шаардлага**

**5.1.1.** Тайлант оны урсгал засварын төсвийн хэмнэлт 17.890.0 мянган төгрөгийг жилийн эцэст татан төвлөрүүлэлгүйгээр “Сэлэнгэ Ундрэм” ХХК-д шилжүүлж, санхүүгийн тайланд авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.7 дахь “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр үүсгэхгүй байх, зарцуулагдаагүй үлдэгдлийг ерөнхий дансанд татан төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.1.2.** Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах гэсэн үндэслэлээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын хэмнэлтийг нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд гүйлгэн Нура төвийн дансанд 5,880.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч үйлчилгээ авалгүйгээр авлага үүсгэсэн байна.

Энэ нь “Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**5.1.3** Үндсэн үйл ажиллагааны давж биелсэн 10,740.0 мянган төгрөгийн орлогыг бүгдийг нь албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санал хүргүүлж, шийдвэрлүүлэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 4 албан хаагчид нийт 9,666.0 мянган төгрөг, ХХОАТ-т 1070.0 мянган төгрөг тус тус шилжүүлсэн боловч 9,666.0 мянган төгрөгийн гүйлгээ баталгаажилгүйгээр төсөвт татагдаж, авлага, өр төлбөрөөр тайлагнагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь “байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах”, 5.1.3 дахь “нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх”, 5.2 дахь “Энэ журмын 5.1.2, 5.1.3-т заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг журмын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.1.4** Тус байгууллага нь 2021 онд 6,855.0 мянган төгрөгийн, 2022 онд 4,935.0 мянган төгрөгийн, 2023 онд 7,625.0 мянган төгрөгийн буюу дунджаар **6,471.6** мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн атал 2024 оны өөрийн орлогыг нэмэгдүүлэлгүйгээр 2,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 12,740.0 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөнөөс давсан 10,740.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь “Энэ журмын 3.1.1-т заасан орлого

*/төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/ -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэл, үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.1.5** Аймгийн Засаг даргын 2023 оны 11 сарын 24-ний өдрийн А/586 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан орон тоонд заагдаагүй жолоочийн ажлын байранд буюу байгууллагын эзэмшилд бүртгэгдсэн авто машингүй атал жолоочийг гэрээтээр ажиллуулан үндсэн цалинд 8,419.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 908.6 мянган төгрөг зэрэг нийт 9,328.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалт болон аймгийн Засаг даргын 2023 оны А/586 тоот захирамжийн 2 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.1.6** Тус газрын дарга буюу төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан, жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр харилцагч аж ахуйн нэгж, байгууллагуудын дансанд шилжүүлж, авлага үүсгэсэн, батлагдаагүй орон тоо буюу жолооч авч ажиллуулсан, холбогдох хууль, журмыг зөрчин үйл ажиллагааны өөрийн орлогыг төлөвлөж, зарцуулсан зэргээр материаллаг хэмжээний зөрчил гаргаж, санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн.		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бодитоор хүлээж аваагүй урсгал засварын материал болон гүйцэтгээгүй ажлын хөлсийг шууд зардлаар бүртгэснийг урьдчилж төлсөн зардлаар бүртгүүлсэн,	1	17,890.0			1	17,890.0	1	17,890.0				
Ажилчдаа Нура төвд эрүүл мэндийн үзлэгт оруулахаар шилжүүлсэн боловч, үйлчилгээ аваагүй байхад шууд зардлаар бүртгэн тайланд тусгасан байсныг урьдчилж төлсөн зардлаар тусгуулсан	1	5,880.0			1	5,880.0	1	5,880.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>23,770.0</b>			<b>2</b>	<b>23,770.0</b>	<b>2</b>	<b>23,770.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хэмнэлтийг хувийн аж ахуйн нэгжид шилжүүлж, авлага үүсгэсэн	1	17,890.0			1	17,890.0						

Төсвийг зориулалт бусаар зарцуулж, авлага үүсгэсэн	1	5,880.0			1	5,880.0					
Үндсэн үйл ажиллагааны давж биелсэн орлогыг журмын дагуу зарцуулаагүй	1	4,296.0			1	4,296.0					
Өөрийн үйл ажиллагааны орлогыг үндэслэлгүйгээр дутуу төлөвлөсөн	1	4,471.6			1	4,471.6					
Албаны машингүй атал гэрээт жолооч авч ажиллуулсан	1	9,328.0			1	9,328.0					
Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн төсвийн шууд захирагчид сахилгын шийтгэл ногдуулах	1									1	
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>41,865.6</b>			<b>5</b>	<b>41,865.6</b>				<b>1</b>	

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	